



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

“Ард даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн 2013 оны хуримтлагдсан ашгаас хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашгийн мөнгөн хөрөнгө болох нийт 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр, хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд хувь тэнцүүлэн нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	“Ард санхүүгийн нэгдэл” ХХК	907 499 613.07	247 499 894.47	1 154 999 507.54	33.00
2	Вэнчэрс Уан Б.В	613 552 628.85	167 332 535.14	780 885 163.99	22.31
3	“Бьюпланэт” ХХК	742 159 155.85	202 407 042.50	944 566 198.35	26.99
4	Д.Чулуунцэцэг	302 538 563.53	82 510 517.33	385 049 080.86	11.00
5	“Энержи интернэшн капитал” ХХК	128 975 027.08	35 17 5 007.39	164 150 034.47	4.69
6	Н.Эрдэнэтулга	55 275 011.62	15 075 003.17	70 350 014.79	2.01
	Нийт	2 750 000 000.00	750 000 000.00	3 500 000 000.00	100.0

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Ард даатгал” ХХК /Д.Чулуунцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

0004/6